



БАТЛАВ. ТУЗ-ИЙН ДАРГА

АУДИТЫН ХОРООНЫ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмаар ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны бүрэлдэхүүн, гишүүдийн бүрэн эрх, зохион байгуулалтын хэлбэр, чиг үүрэг, тогтоол шийдвэр, санал, дүгнэлт гаргах зэрэг хорооны үйл ажиллагаатай холбогдсон бусад харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Аудитын хороо нь чиг үүргийнхээ хүрээнд тодорхой асуудлаар санал, дүгнэлт гарган ТУЗ-д танилцуулах, хууль тогтоомжид заасан зарим асуудлаар тогтоол шийдвэр гаргах эрхтэй байна.

Хоёр. Хорооны бүрэлдэхүүн

- 2.1 Аудитын хороо нь 3-аас доошгүй ТУЗ-ийн гишүүдээс бүрдэх бөгөөд хорооны гишүүдийн 2/3-оос доошгүй нь хараат бус ТУЗ-ийн гишүүн байна.
- 2.2 Аудитын хорооны дарга, гишүүдийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооноос санал болгож, ТУЗ-ийн хурлаар томилно.
- 2.3 Хорооны гишүүн бүр нь санхүүгийн боловсролтой байх бөгөөд хамгийн багадаа нэг гишүүн нь санхүү, эдийн засаг, нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэн байна.

Гурав. Хорооны гишүүдийн бүрэн эрх

- 3.1 Аудитын хорооны гишүүд нь бүрэн эрхтэй байна. Үүнд:
 - 3.1.1 Хуралд саналын эрхтэй оролцох
 - 3.1.2 Санхүүгийн тайлангийн явцыг хянах
 - 3.1.3 Компанийн аудиторыг томилох, цалин урамшууллын хэмжээг тогтоох, тодорхой асуудлаар хяналт шалгалт хийх, ажлын гүйцэтгэлтэй танилцах, үнэлэх
 - 3.1.4 Компанийн санхүүгийн тайлан, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн зөв бодит байдалд хяналт тавих, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, хөндлөнгийн шалгалт хийх хараат бус аудиторт тавигдах хараат бус байдлын болон мэргэшил, ажлын туршлага, бусад шалгуур үзүүлэлтийг тогтоож, хараат бус аудиторын эрх, үүрэг, хариуцлага, аудиторт төлөх хөлсний хэмжээ, бусад гэрээний нөхөцлийн талаар санал боловсруулан ТУЗ-өөр шийдвэрлүүлэх
 - 3.1.5 Хараат бус аудиторын дүгнэлт, тайланг хэлэлцэн, шаардлагатай зүйлийг асууж тодруулах замаар асуудлын мөн чанарыг таньж мэдсэний үндсэн дээр хяналтын системийг боловсронгуй болгох, урьдчилан сэргийлэх арга хэлбэрийг тодорхойлж, компанийн удирдлага, холбогдох албан тушаалтанд үүрэг, чиглэл өгөх, хараат бус аудиторын зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавих

- 3.1.6 Шаардлагатай гэж үзвэл ТУЗ-ийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах мөн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулахыг шаардах, түүгээр хэлэлцэх асуудлыг санал болгох, дотоод хяналтын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, шаардлагатай тохиолдолд гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг түдгэлзүүлэх
- 3.1.7 Хорооны үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг хангуулах, шаардлагатай мэдээ мэдээлэл, баримтыг саадгүй гаргуулах, холбогдох мэдээллийг гаргаж өгөөгүй ажилтан албан хаагчдад хариуцлага тооцох саналыг гүйцэтгэх удирдлагад санал оруулах

Дөрөв. Хорооны хурал

- 4.1 Аудитын хорооны зохион байгуулалтын хэлбэр нь чухал байна.
- 4.2 Хурал нь хуралдааны болон эчнээ, цахим хэлбэртэй байж болно.
- 4.3 Аудитын хороо нь улирал нэг удаа хуралдах бөгөөд шаардлагатай тохиолдолд нэмэлт хурлыг зохион байгуулж болно.
- 4.4 Хуралд гишүүдийн 2/3 оролцсоноор хүчин төгөлдөр болох бөгөөд бусад этгээд оролцохгүй. Харин шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийнх дарга, гишүүд, гүйцэтгэх удирдлага хорооны урилгаар оролцож болно.
- 4.5 Хурлыг хорооны дарга удирдаж, нарийн бичгийн дарга зохион байгуулна.
- 4.6 Хорооны хурлын хэлэлцэх асуудлыг хорооны дарга, гишүүд, нарийн бичгийн дарга нар хариуцан оруулна.
- 4.7 Хороо нь хурлаар хэлэлцсэн асуудлынхаа хүрээнд санал, дүгнэлт, зөвлөмж, тогтол гаргана
- 4.8 Хурлаас гарах тогтоолыг олонхын саналаар батлах бөгөөд санал тэнцсэн тохиолдолд Хорооны дарга шийдвэрлэх санал өгнө.

Тав. Эрх мэдэл

- 5.1 Аудитын хороо нь компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагааны бүхий л хүрээг хамрах хяналтын тогтолцоог бүрдүүлэх бөгөөд хяналтын тогтолцоо нь чадварлаг хараат бус, компанийн зохистой ажиллагаа, үр ашгийг нэмэгдүүлэхэд бодитой хувь нэмрээ оруулж, түүнийг эрсдэлээс сэргийлж чаддаг байна.
- 5.2 Аудитын хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулна.
- 5.2.1 Компанийн санхүүгийн үйл ажиллагаа батлагдсан төсөв төлөвлөгөөний дагуу явагдаж байгаа эсэх, төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх
- 5.2.2 Компанийн санхүү, нягтлан бодох бүртгэлийг үнэн зөв хөтөлж байгаа эсэх, хөндлөнгийн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх, санхүүгийн тайлагнал нь нягтлан бодох бүртгэл, олон улсын стандартад нийцэж байгаа эсэхэд хяналт тавих
- 5.2.3 Санхүү татвар болон үйл ажиллагааны бусад чиглэлээр хийсэн шалгалтын дүгнэлт, материалтай танилцах, тэдгээрт илэрсэн зөрчлийг арилгасан эсэх, зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэхэд хяналт тавих
- 5.2.4 Санхүүгийн удирдлага зохистой эсэх, хийгдэж байгаа гэрээ хэлцэл их хэмжээний сонирхлын зөрчилтэй хэлцэл болох эсэх
- 5.2.5 Компанийн дотоод хяналт, журмуудын хууль дүрэмд нийцсэн байдал, журмуудын хэрэгжилтэд хяналт тавих
- 5.2.6 Хөндлөнгийн аудитыг зохих ёсоор гүйцэтгэсэн эсэх
- 5.2.7 Компанийн эрсдэлийг удирдах бодлого, стратегийг тодорхойлох, тэдгээр нь шаардлага хангахуйц, үр дүнтэй эсэхэд хяналт тавих, эрсдэлийн удирдлагын хэрэгжилтэд хяналт тавих

- 5.2.8 Дотоод хяналтын албаны үйл ажиллагаа зохистой байгаа эсэх
- 5.2.9 Мэдээллийн нээлттэй, ил тод байдал хангагдаж байгаа эсэх, гадагш мэдээлж байгаа мэдээллийн үнэн зөв байдал, компанийн нууцлал болон дотоод мэдээлэл алдагдсан эсэх
- 5.2.10 Компанийн удирдлага, эрх бүхий албан тушаалтан, ажилтны үйл ажиллагаа зохистой байгаа эсэх, хууль, дүрэм, ёс зүйн хэм хэмжээг баримтлаж байгаа эсэх
- 5.2.11 Хууль тогтоомжид заасан эсвэл ТУЗ-с тодорхойлсон бусад асуудлаар дүгнэлт гаргах

Зургаа. Ажлын тайлагнал

- 6.1 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь Аудитын хорооны хурлын тэмдэглэлийг ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагад хүргүүлнэ. Хурлын тэмдэглэлд хурлаах хэлэлцсэн асуудал, санал дүгнэлт асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн зэрэг байна.
- 6.2 Аудитын хороо нь албан үүргийнхээ хүрээнд гүйцэтгэх чиг үүрэг, хариуцлагын дагуу хийсэн ажлаа ТУЗ болон ХЭХ-д тайлагнана.

Долоо. Журамд өөрчлөлт оруулах

- 7.1 Хороо нь энэхүү журмын заалтуудад нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТУЗ-д санал оруулж шинэчлэн батлуулж болно.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

